



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/88

Хажуу шинэ ус

Хязгаарлалтын дэглэмийг
хорио цээрийн дэглэмд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалт, Малын эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дахь заалт Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн 2022 оны 09 сарын 21 шинжилгээний 22-3709, 22-3710 дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Морьт багийн нутаг "Хар даравгай" /46.186368, 107.415949 /, "Цагаан даравгай" /46.150718, 107.409494/ нутагт бог малын мялзан өвчний голомт үүссэн тул 2022 оны 9 сарын 23-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэмийг тогтоосугай.


2.Хорио цээрийн бүсэд хийгдэх халдваргүйжүүлэлт, дархлаажуулалтыг зохих заавар журмын дагуу чанартай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн тасаг, Угтаал чандмань хоршоо мал эмнэлэг үйлчилгээний нэгжид үүрэг болгосугай.

3. Хорио цээрийн дэглэмийн үед шаардагдах хоол хүнс, шатахуун, ажлын хөлс, бусад зардалд шаардагдах 3.000.000 (гурван сая) төгрөгийг Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн Байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардлаас гаргаж зарцуулахыг Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох) нягтлан бодогч (Э.Уранбилэг) нарт зөвшөөрсүгэй.

4.Хүн малын шилжилт хөдөлгөөнд, хяналт тавьж, хяналтын постыг ажиллуулан хорио цээрийн дэглэмийг мөрдөж хэв журам сахиулж ажиллахыг багийн Засаг дарга нар, хэсгийн цагдаа (Б.Наранбаатар) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ӨМӨНХ-АМГАЛАН



482201080